**3.Ховд хотын геоэкологи, гидрогоеологийн судалгаа Ховд геоэкологи-2021 төсөл:** Ховд хотын хэмжээнд нийтдээ 1978  $\text{km}^2$  талбайд 23 хавтгайд геоэкологи, геоморфологи, гидрогоеологийн 1:25000-ны масштабын зураг зохиогдон үр дүнгийн тайлан бичигдсэн. Төслийн талбайн хэмжээнд хөрс, газрын доорх усны чанар, бохирдолд өртөмтгий байдал, агаарын бохирдол, цэвдэг, гадаргын усны бохирдол, үерийн эрсдэл, геологийн эндоген, экзоген болон техноген зэрэг бүрэлдэхүүн 10 хүчин зүйлийг үндэслэн геоэкологийн эрсдэлийг үнэлж, нэгдсэн үнэлгээний зураг зохиогдсон. Ховд хотын ус хангамжийн эх үүсвэрийн сүүлийн судалгаагаар батлагдсан нөөц  $16,070 \text{ m}^3/\text{хоног}$ , үүнээс ашиглаж байгаа нь  $3,900 \text{ m}^3/\text{хоног}$  гэж судалгаагаар тогтоогдож, Усны газраар батлагдсан нөөцийн

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
								24.3%, 1990 оноос өмнө хийсэн судалгаагаар 13730 м <sup>3</sup> /хоног тогтоогдож батлагдсан нөөцтэй байсан бөгөөд түүний 28.4 хувийг ашиглаж байгаа нь энэхүү эх үүсвэрийг хангалттай гэж үзэж байна. Мөн ховд хот нь 2020 оны шинэчилсэн ерөнхий мужлалтын зургаар хадан хөрсний хувьд 201-240см/сек <sup>2</sup> & 281-310см/сек <sup>2</sup> буюу VIII баллын бүсэд хамаарна. Судалгааны талбайд орших техноген тогтолцооны төрөлжүүлэлтийг хийн шинэ ховд суурьшлын бүс, үйлдвэрлэл технологийн парк, агропарк цогцолбор, олон улсын нисэх буудал зэрэг хэтийн төлөв бүхий техноген обьектууд байгуулагдах талбай ялгагдсан. Тайланг ЭБМЗ-ийн 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн УТХ-2024-04 дүгээр хурлаар хэлэлцэгдэн хамгаалагдсан.		

**4. Гүний хагарал-1 төсөл:** Монгол орны төв болон хойд хэсгийг хамрах 602,984.0 км<sup>2</sup> талбайд Гүний хагарал, Идэвхтэй хагарал Палеосейсмологийн судалгаа, Морфологи структурын судалгаа, Геотермийн судалгаа, Гидрогеологи, рашаан булгийн судалгаа, Геоэкологийн судалгаа, Гидрогеотермийн судалгааг гүйцэтгэсэн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн УТХ-2024-08 дугаар хурлаар хэлэлцэгдэн онц сайн үнэлгээтэйгээр хамгаалагдсан. Төслийн хүрээнд нийт гүний 18, идэвхтэй болон боломжит 61, болон идэвхтэй байж болзошгүй 130 гаруй хагарал түүний сегмент, 37 халуун рашаан, 48 хүйтэн рашаан, 5 цацраг идэвхт хийтэй рашаан, эмчилгээний 22 нуур, эмчилгээний зориулалтаар орон нутгийн түвшинд ашиглаж буй 18 рашаан төстэй булаг, гүний хагарал болон идэвхтэй хагарлын бүсэнд сууж байгаа 187 булаг, нийт 526 обьектод хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэн үр дүнгийн тайлан боловсруулагдсан. Газар хөдлөлийн аюулын үнэлгээний хувьд төслийн хүрээнд нийт

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									22 хавтгайд мөн Завхан аймгийн төв Улиастай хот, Хөвсгөл аймгийн төв Мөрөн хот болон Булган аймгийн төв дээр аюулын үнэлгээний зургийг зохиосон. Мөн идэвхтэй байж болохуйц (Авдар, Эрхэл нуур, Хаг нуур, Тоом гол, Хогоргын гол, Идэр, Моностой, Хужирт) 8-н хагарал дээр палеосейсмологийн судалгаа хийж хагарлын нас болон давтамжыг тодорхойлсон. Халуун рашаануудын гүний температурыг хэд хэдэн геотермометрийн аргыг ашиглан тооцсон бөгөөд гүний температур нь 99.6-130.4°C хооронд хэлбэлзэх бөгөөд эргэлтийн гүн нь 1.4-2.9 км байх боломжтой байна. Судалгааны талбайн хэмжээнд гео-аялал жуулчлалын холбогдох мэдээллийг нягтлан шалгажхэтийн төлөв маш сайн 8, хэтийн төлөв сайн 7, хэтийн төлөв дунд 7 талбайг тус тус ялгаж, бусад нутгийг хэтийн төлөв тодорхойгүй ангилалд хамруулан, геожуулчлал хөгжүүлэхэд давуу ба сул талуудыг тодорхойлж зөвлөмж гаргасан.	

**5. Монгол Улсын босоо тэнхлэгийн бүсэд 2022-2024 онд хэрэгжүүлэх гео-орчин төсөл.** Төслийн хэмжээнд Гео-орчны зураг /масштаб 1:200000/, Гео-орчны эрсдэлийн үнэлгээний зураг, Баримт материалын зураг, Гео-экологийн зураг, Гео-экологийн аюулын үнэлгээний зураг, Геоморфологийн зураг, Гео-гамшгийн зураг, Гео-гамшгийн аюулын үнэлгээний зураг, Газар хөдлөл идэвхтэй хагарал, түүнтэй хам хөгжилтэй геологийн хүчин зүйлийн зураг, Газар хөдлөл идэвхтэй хагарал, түүнтэй хам хөгжилтэй геологийн хүчин зүйлийн урьдчилсан аюулын үнэлгээний төрөл зэрэглэлийн зураг, Гидрогеологийн зураг, Гидрологийн зураг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын зураг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хэтийн төлөв-үнэлгээний зургууд зохиогдон тайлбар бичиг, мэдээллийн сан бүхий үр дүнгийн тайлан

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									зохиогдож ЭБМЗ-ийн хурлаар оруулж хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг гүйцэтгэж байна. Тус талбайн хэмжээнд өмнөх судалгаагаар түгээмэл тархацтай ашигт малтмалын 306 орд, 40 илрэл тэмдэглэгдсэн байдаг Төслийн ажлын үр дүнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хэтийн төлөвтэй байж болох элсний 15, элс-хайрганы холимогийн 12, шаврын 5, барилгын чулууны 41, өнгөлгөөний чулуу 11, нийт урьдчилсан байдлаар 81 илрэл тогтоогдоод байна. Үнээс уулын ажил, геофизикийн ажил болон дээжлэлийн үр дүнгээр 20 илрэлд баялаг тооцсоноос барилгын элсний 3 талбайд Р зэргээр 5.6 сая м.куб, барилгын чулууны 8 талбайд Р зэргээр 14.2 сая м.куб, элс хайрганы 6 талбайд Р зэргээр 9.8, Өнгөлгөөний чулууны 2 талбайд Р зэргээр 8.2 сая м.куб, шаврын 1 талбайд Р зэргээр 3.2 сая м.куб баялаг тооцов.	
	7	Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийнэ.	2020-2024	АУЭБЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 18,000.0  2024 оны байдлаар гүйцэтгэл: 2,997.7	Тек-2021, ТЗ-2024 төслийн үр дүнгийн тайланг хүлээн авах, ЭТЭ-2022, Геофизик-2023 төслийг үргэлжлүүлэх, Геохими 2024 төслийг эхлүүлнэ.	<b>1.Мезо-Кайназой-2021</b> Монгол орны хэмжээнд тархсан мезо-кайнозойн хурдасны түвшинд шийдэгдээгүй олон асуудал (стратиграфийн нэгжийн нэрсийн давхардал, үндэслэл, үнэмлэхүй нас, зүсэлт, хил заагийн маргаан)-ыг шийдвэрлэж, баталгаажуулж түүндээ тулгуурлан геологийн 41 лист, ашигт малтмалын 41 лист, тектоникийн 41 листийн зургуудыг тус тус анх удаа 1:500000-ны масштабаар зохиогдож, дагалдан 74 төрлөөр мэдээллийн сан бүрдүүлсэн, үнэмлэхүй насны 66 шинэ өгөгдөл, дээжийн тодорхойлолт, тунамал ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээ бүхий тайлбар бичиг зохиогдсон. Үр дүнгийн тайлан Улсын геологийн зургийн редакцаар хянагдаж байна. <b>2.БМШАМ-2022.</b> Баруун Монголын зарим бүсийн тектоник ба шатах ашигт малтмалын хэтийн төлөвийн судалгаа төсөл 2022 оноос эхлэн хэрэгжсэн.	100%	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
								Судалгааны талбайн байршил: Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтайн зарим хэсэг 97,244,83 кв.км талбайд хавтгайн номенклатур М-46-А, Б, В, Г; L-46-А-Б /хэсэгчлэн/ БМШАМ-2022 кодтой төслийн суурин боловсруулалтын ажил 2024 оны 12 дугаар сарын 31-нд дуусахаар гүйцэтгэж байна. Тайлангийн шуурхай хяналтыг 2024 оны 04 дүгээр сарын 09-нд болон 2024 оны 09 дүгээр сарын 20-нд 2 удаа хийж гүйцэтгэсэн.		
	8	Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, ОХУ, БНХАУ, БНСҮ, БНКазУ зэрэг гадаад орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд геологийн судалгааны ажил хийнэ.	2020-2024	АҮЭБЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 6,500.0 2024 оны байдлаа р гүйцэтгэл: 826.1	ОХУ, БНХАУ, БНСҮ, БНКазУ-тай хамтарсан геологийн судалгааны ажлын 6-р үе шатны ажлыг эхлүүлэх, бусад орнуудтай харилцан үр ашигтай төсөл хэрэгжүүлнэ.	"Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени" төслийн ОХУ, БНХАУ, БНСҮ, БНКазУ-тай хамтарсан геологийн судалгааны ажлын 5-р үе шат Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн /УТХ-2024- 06-03 дугаар/ хуралдаанаар Төв Ази 3D 5-р үе шат төслийн үр дүнгийн тайлан хамгаалагдсан. Төслийн ажлаар Монгол орны нутаг дэвсгэрт Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь аймгуудын нутаг дэвсгэрт байрших Алтайн нурууны үргэлжлэлийг хамарсан 1_-47-XIX, XX, XXI, XXII, XXV, XXVI, XXVII, XXVIII, XXIX, XXX, XXXIII, XXXIV, XXXV, XXXVI, ^-48-XXV, XXXI нийт 16 хавтгайн хэмжээнд 1:500000-ны масштабтай геологи, тектоник, геоэкологи, металлогенийн зургийг тайлбар бичвэрийн хамт зохиосон. Геологийн зургийг гадаад дотоодын судлаачдын судалгааны материалыуд болон төслийн ажлын үр дүнг ашиглан боловсруулж зохиосон ба зарим нэмэлт өөрчлөлтүүд хийгдсэн. Давхаргазүйн 81 формац, 50 интрузив бүрдлийг ялгаж, геодинамикийн орчинг 3 бүсэд тодорхойлсон. Монгол Алтайн металлогенийг зэргэлдээ орнуудын геодинамикийн нөхцөл болон ашигт малтмалын зүй тогтолтой харьцуулан акрец-коллизийн ба рифт-плюм тектоникийн гэж ялгасан. Экологи- geoхимийн судалгааны ажлын үр дүнгээр боловсруулалт хийж, талбайн	100%	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									хэмжээнд хүдэржилтийн шинж бүхий элементүүдийн геохимиийн эвшлүүдийн тархалтын зургийг зохиосон. Төслийн талбайн геодинамикийн зургийг “Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” 4-р үе шатны төслийн хүрээнд зохиогдсон зурагтай нэгтгэн 1:1000000-ын масштабаар боловсруулан, товч тайлбар бичгийн хамт хийсэн. Говийн Алтайн уулсын геологийн иж бүрдэл зурагт (геологи, экологи, тектоник, металлогени) оролцогч улс орнуудын судалгааны шинэлэг мэдээллүүдийг тусгаж, ОХУ-ын “ВСЕГЕИ” хүрээлэнгийн заавар, арга аргачлалын дагуу хийсэн.	
3.2.4.Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.	9	Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг төслийг магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна	2020-2024	АҮЭБЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 2,000.0 2024 оны байдлаа р гүйцэтгэл: 2,909.31	Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөтөлбөрийн төрөлжсэн мэдээллийн сан хүлээн авах, мэдээлэл түгээх үйлчилгээ хялбар болгосон байх, ажлын явц 100%	<b>Геомэдээл-2019.</b> Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн системийг Үнэмлэхүй нас-1119, Интрузив чuluулаг-3362, Эффузив чuluулаг-360, Палеонтологийн олдвор-3567, Горизонт-61, Стратиграфи /давхарга зүйн сан/-706, Уст цэг /худаг/-8200, Булаг-3100, Илрэл-5418, МонГеоСат/метадата/-4880, Цахим бутээлийн сан үүсгэх-5833, Шлихийн хүрээ-2966, Цооног-5600, Өрөмдсөн цооног-920 Эрдэсэжсэн цэг-201, Чулуун дээж-1039, Шлиф-2893, Аншлиф-330, Идэвхтэй хагарал-301, Гүний хагарал-2350. Нийт <b>20270</b> мэдээллээр баяжуулж мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулсан.	100%	
	10	Геологийн чuluун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах,	2020-2024	АҮЭБЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 6,000.0 2024 оны байдлаа р	Геологийн чuluун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэлтийн төслийг	<b>Чулуун дээжийн сан-1-2022.</b> Чулуун сангийн агуулахад байгаа ордуудын дээжийг бүртгэх, системд оруулах ажлын хүрээнд нийт 165 ордын чулуун дээж- <b>6904</b> , чөмгөн дээж- <b>776</b> , шлиф- <b>24535</b> , аншлиф- <b>3056</b> , технологийн дээж-6 ширхэг буюу <b>1973</b> ширхэг дээжийг бүртгэлжүүлсэн.	100%	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
			мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна			гүйцэтгэл: 1,631.0	ургэлжлүүлэх, мэдээлэл түгээх ажлын явц 100%	Чулуун дээжийн фото зураг авах ажлын хүрээнд дээжийн- <b>2165</b> , шлифийн- <b>2700</b> , аншлифийн-52 ширхэг фото зургийг авч мэдээллийн бичвэрийг хийгээд байна. Тайланийн хавсралт материалыаас <b>17422</b> лабораторийн үр дүнгийн хариуг сканер хийн, оруулсан. Цахим архивыг баяжуулах ажлын хүрээнд <b>10255</b> тайлан, <b>19376</b> хадгаламжийн нэгжийн хэмжээнд 7 дансны мэдээлэл боловсруулж мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулсан.		
3	3.2.5. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүү лэх замаар эрдэс	11	Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө.	2020-2024	АҮЭБЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 5,686.1  2024 оны байдлаа р гүйцэтгэл: 5,086.6	ГАСАМ болон ГХЭ-ийн хэтийн төлөвийн судалгааны ажлын төслүүдийн үр дүнгийн тайланг хүлээн авах. Өндөр технологийн түүхий эдийн судалгааг ургэлжлүүлнэ	<p><b>1.ГАСАМ-2017.</b> Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэсэн ГАСАМ төслийн үр дүнгийн тайлан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар хамгаалагдсан. Хурлын тэмдэглэл, дүгнэлтийг Аж үйлдвэр, эрдэс баялагийн яаманд хүргүүлсэн.</p> <p>ГАСАМ кодтой Стратегийн ашигт малтмалын хэтийн төлөвийн судалгааны ажлын үр дүнгээр стратегийн ашигт малтмал агуулж болох хүдэржилтийн 5 үндсэн гарал үүслийн 11 бүлэгт ордын төрлийг тодруулсан.</p> <p>Монгол улсын хувьд хэтийн төлөвтэй байж болох лити, газрын ховор элемент, tantal, ниоби, берилли, бал чулуу, никель, кобальт зэрэг ашигт малтмалын төрлүүдийг сонгон эдийн засгийн бүсчлэлд тулгуурлан орон зай, гарал үүслээр нь тодорхой хүдэржилтийн бүсүүдийг ялгаж цаашид стратегийн ашигт малтмалын салбарт баримтлах зөвлөмжийг боловсруулсан.</p> <p>Геологийн судалгааны дараагийн шатны ажил явуулах лити, газрын ховор элемент, бал чулууны хэтийн төлөв бүхий бүсүүдийг болон орчин үеийн дэвшилтэд технологи ашиглан агаарын геофизикийн судалгааны ажлаар эрэл үнэлгээ явуулах боломжтой лити, никель-кобальтын хэтийн төлөвтэй 2 талбай ялгасан.</p>	100%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
	баялгийн нөөцийг арвижуулна.								Стратегийн ашигт малтмалын жагсаалтад БНХАУ-аас бусад улс орон оруулаагүй боловч Монгол орны хувьд цэвэр эрчим хүчний эх үүсвэр болох, нөгөө талаас шингэрүүлсэн тос нь нефть боловсруулах үйлдвэрийн түүхий эд болох боломжтой шатдаг занарыг судлан, хэтийн төлөвийг үнэлж, дүгнэлт өгсөн. <b>2.ӨТТЭ-1.</b> Увс, Завхан, Хөвсгөл, Өмнөговь, Дорноговь аймгуудын нутагт гүйцэтгэсэн Өндөр технологийн түүхий эд-1 төслийн үр дүнгийн тайланг эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар хамгаалагдсан. Хурлын тэмдэглэл, дүгнэлтийг Ул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. “Геологийн судалгаа шинжилгээний төв”-ийн гүйцэтгэсэн ӨТТЭ-1-2021 төслийн нарийвчилсан эрлийн ажлаар судалгааны 4 том талбай, эрэлшалгалтын 46 жижиг талбайнуудыг ялгаж, 37 илрэл, 88 эрдэсэжсэн цэг болон цэгэн гажлуудыг шалгасан. Эрэл-зураглалын ажил нийт 12 талбайд, түүнээс 1 талбайд эрэл-үнэлгээний ажлыг хийж зохих стандарт, аргачлалын дагуу нөөц, баялгийн үнэлгээг өгсөн. Ихэрийн ГХЭ болон Zr-Nb-ийн хүдэржилттэй илрэлийн хэмжээнд эрэл-үнэлгээний ажил гүйцэтгэж боломжтой С зэрэглэлээр 395.6 мян.тонн хүдэрт 0.22 %-ийн дундаж агуулга бүхий 852.8 тн ГХЭ <sub>нийлбэр</sub> ислийн нөөц, 0.15 %-ийн дундаж агуулга бүхий 589.4 тн Nb <sub>2</sub> O <sub>3</sub> , 1.16 %-ийн дундаж агуулга бүхий 4580.7 тн Zr <sub>2</sub> O <sub>3</sub> нөөц тооцсон. P <sub>1</sub> зэргээр илрүүлсэн баялгийг 1005.8 мян.тонн хүдэрт 0.24 %-ийн дундаж агуулга бүхий 2527.3 тн ГХЭ нийлбэр исэл, 0.16 %-ийн дундаж агуулга бүхий 1613.1 тн Nb <sub>2</sub> O <sub>3</sub> , 1.26 %-ийн дундаж агуулга бүхий 12,195.1 тн Zr <sub>2</sub> O <sub>3</sub> гэж үнэлсэн. Никелийн хүдэржилт бүхий Хаг эрлийн хэсэгт БНСҮ-ын КИГАМ (геологи, ашигт малтмалын	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									хүрээлэн) байгууллагатай хамтран эрлийн ажил болон агаарын соронзон хайгуулын ажлыг гүйцэтгэж, урьдчилсан байдлаар баялгийн үнэлгээг Р зэргээр никелийн 390.5 сая тонн худэрт 663.9 мян.т металл, хромын 269.2 сая тонн худэрт 430.8 мян.тн металл тооцсон.	
	12	Үнэт, өнгөт, хар, ховор, холимог, металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн	2020-2024	АУЭБЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 39,325.1 2024 оны байдлаа р гүйцэтгэл: 24,764.4	Үнэт, өнгөт, хар, металл, металл бус ашигт малтмалын металлын эрэл, үнэлгээний ажлын үргэлжлүүлэх, хэтийн	<b>3.ӨТТЭ-2.</b> Демон инженеринг" ХХК-ийн хэрэгжүүлж буй Өндөр технологийн түүхий эд-II төслийн нарийвчилсан эрлийн ажлаар ГХЭ-ийн Мушгия худгийн худрийн дүүрэг, бүсэд газрын ховрын хэтийн төлөвтэй талбайнууд нэлээд тогтоогдож, Дундговийн болон Өмнөд Хэнтийн бүсэд газрын ховор элементийн цэгүүд илэрсэн. Хэтийн төлөв бүхий ГХЭ-ийн Өлгий хийд, Нарийн уулын, ГХЭ- барит-целестин-стронцианитын худэржилт бүхий Баянхшуу илрэл, Эрлийн талбай-1 /Мушгия худаг-Зүүн/-д ялгасан ГХЭ-ийн Хар толгой, Жоншит, Бор толгойн талбайнууд, ГХЭ-ийн Дэлгэрхангай бүлэг эрдэсэжсэн цэгүүд. Литийн Хэцүү тээг болон Тээг уулын болон Дөрвөн дэртийн талбай, Зос уул, Урт гозгор, Бууралхангайн илрэлүүд, Талст графитын Хөх хад-1 ба 2 бүлэг илрэлүүд дээр 2024 оны хээрийн нэмэлт ажлууд хийгдсэн. ӨТТЭ-2-2022 төслийн суурийн боловсруулалтын ажлыг 2024 оны 12 дугаар сарын 31-нд дуусгахаар гүйцэтгэж байна.	90%	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
			төлөвийн үнэлгээ өгнө.					төлөвийн үнэлгээ өгнө.	тус бүрийг шалгасны дүнд 110 талбайд 202 илрэл, 127 эрдэсэжсэн цэг, 2 цэгэн гажил, 2 сарнилын хүрээг ялгасан. Хэтийн төлөвтэй байж болох 113 илрэл буюу 170 км <sup>2</sup> талбайд эрэл, нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажлаар 11 илрэл /Шивээн голын Au-Ag, Майхан цахир толгойн Au-Cu, Хүрэн цавын Au, Халзангийн Cu, Хондлойн холимог, Даргиатын Au-холимог, Шар хөндийн Au, Овоот хярын хойд Au, Өлзийт овоогийн Cu-Au, Их Аргалантын Cu-Au, Хойд Бүргэдийн Au/ орд болох боломжтой. 17 илрэлд дараагийн шатны ажил гүйцэтгэвэл орд болох магадлалтай /Алташийн Cu-холимог, Яргайтын ховор, Ширдэгтийн Au-Cu, Хар бэлчээрийн Au-Cu, Цахир толгойн Au, Цалгайтын Au, Ноён уулын Au, Залаагийн Fe, Онгон тээгийн Cu-Ag, Хамба судлын Au, Зараагийн Cu, Мөрөгцөгийн Au-Cu, Алаг толгой-1, 2 Au-Ag, Номтын Cu, Аман усны Cu-Ag, Цагаан уулын Mo (Au)/ бусад 50 илрэлийн хэтийн төлөвтэй цаашид судлах, Хойт бүргэдийн алтны үндсэн ордын хэмжээнд 43 цооног, 13391ш керний дээж, 13 суваг малтаж, захын агуулгыг 0,25 г/т /гоц өндер агуулгыг хязгаарлаж тооцсон/, нөөцийг 43,62 тн хэмээн тооцсон. Алтны 20 илрэлд баялгийг шинээр тооцсон 11 илрэлийн хэмжээнд Р1 зэргээр 49,16 тонн, Р2 зэргээр 37,2 тонн_ алтны нийт 130 тн баялаг тооцсон /Шивээтийн голын Au-Ag, Майхан цахирын Au-Cu, Хүрэн цавын Au, Даргиатын Au-холимог, Шар хөндийн Au, Овоот хярын хойд Au, Өлзийт овоогийн Cu-Au, Их Аргалантын Cu-Au, Адуунчuluу Au, Бага уул Cu-Au/ Голлох ашигт малтмалын 1000 орд, 6058 илрэл, 82250ш дээж, сорьцын мэдээллийн санг боловсруулсан. Баруун бүсэд 1914 илрэл, Төвийн бүсэд 1381 илрэл, Хангайн бүсэд 1295 илрэл, Зүүн бүсэд 1483 хэтийн төлөвтэй илрэл бүртгэсэн бөгөөд дахин судлах шаардлагатай. Голлох ашигт малтмалын 1040 илрэлд баялаг тооцсон: Au -10.2	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									мян.т, Ag 29.4 мян.т, Cu 6 сая тн, Fe 183 сая тн, Pb 1.2 сая тн, Zn 1.2 сая тн, Mo 150 сая тн, W 490.1 мян.т, Sn 96.8 мян.т, CaF <sub>2</sub> 911.1сая тн. Ордын хувьд 1000 гаруй ордын нийт нөөц: Au -2,9 мян.т, Ag 39,6 мян.т, Cu 79,4 сая тн, Fe 1,8 т.б тн, W 731 мян.т, Mo 1,5 сая тн, ГХШЭ 1,14 сая тн, нүүрс 26,6 тэрбэм тн, шатдаг занар 789 сая тн тогтоогдсон. Монгол орны металлогений дүүрэгчлээр Баруун бус-д 4 их муж, 23 бусийн хэмжээнд нийт 13 дүүрэгт алт, вольфрам, зэс, мөнгөний илрэлүүд болон Төв ба Хангайн бусийн 7 их мужийн 28 бусийн хүрээнд нийт 30 гаруй дүүрэгт Au, Fe, Cu-ийн хэтийн төлөвтэй илрэл зонхилох ба Mn, W, Mo, Pb, Sn, Zn, Ag, Al, Li, Sb, ГХЭ-ийн илрэлүүд хэтийн төлөв сайтай нөөц ёсгэх боломжтой илрэлүүдийг ялгасан. Монгол орны хэмжээнд нийт 750 орд, 1040 илрэл /орд болох 214/ тус бүрд мэдээллийн сан дагалдуулж, зургийн тоон мэдээлэлтэй холбосон. Нийт бусийн хэмжээнд 43962 кв.км буюу 18 талбайд /36 хавтгай/ 1:50000-ны ГЗЕЭА-ыг шинээр хийх зөвлөмжийг гаргасан. Нүүржилтийн 3 муж, 15 сав газар, 2 талбай, 33 дүүрэг ялгажээ. Өмнө нь үнэлгээ өгөгдөөгүй хайлуур жоншны илрэл, эрдэсэжсэн цэг бүхий хэтийн төлөвтэй 11 талбай, Завханы сав газарт фосфоритын 3 талбай, бал чулууны хүдэржилтийг хүдрийн 3 дүүрэг, 10 бусэд ангилж, нэмэлт судалгаа явуулах шаардлагатай 38 илрэлийг тэмдэглэсэн. Голлох ашигт малтмалын тархалтын зурагт нийт 150 илрэлийг хэтийн төлөвтэй, 406 илрэлийг дахин судлах шаардлагатай гэж үзсэн. Ашигт малтмалын ашиглалтын 1732 тусгай зөвшөөрөл бүхий ордуудаас 20 нэр төрлийн ашигт малтмалын 522 ордод ашиглалтын өмнөх чадамжийг нь үнэлэх аргачлалын дагуу үнэлгээ хийх гэсэн зөвлөмж гаргасан үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									<p>06 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар орж хамгаалагдсан</p> <p><b>2. Эрэл-үнэлгээ - 1 - 2020.</b> Терра сийд ХХК-ийн Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт 3 хэсэг талбайд 2020-2022 онуудад гүйцэтгэсэн төслийн үр дүнгийн тайлан эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хурлаар хамгаалагдсан.</p> <p><b>3. Эрэл-үнэлгээ - 2 - 2021.</b> Меланж сурвей ХХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций, Мандал -Овоо, Ханбогд, Манлай, Баян-Овоо, Дорноговь аймгийн Мандах сумын нутагт гүйцэтгэсэн Эрэл үнэлгээ-2-2021 төслийн үр дүнгийн тайлан эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 05-07-ны өдрийн хурлаар хамгаалагдсан.</p> <p>Мандал талбайн шохойн чулуу нь үйлдвэрлэлийн 1-р зэргийн шохой болон мөн алтны үйлдвэрийн баяжуулалтад нэмэлтээр ашиглах боломжтой. Алтны хүдрийн хэмжээ бага_ агуулга ядуу учир цаашид эрэл-хайгуулын ажил хийх хэтийн төлөв багатай.</p> <p>Зараа талбайн сульфидын хувирлын бүсүүд тогтоогдсон боловч зэс-порфирийн төрлийн гарал үүсэлтэй хүдэржилт үүсгэх хэмжээнд бус ба цаашидын эрэл ажлын хэтийн төлөв муутай. Суваг малтлалтын үр дүнгээр зэсийн дундаж агуулга 0.25-0.3%. Онгон тээгийн талбайн хувирлын бүс тасалдалтай, хэмжээ бага, зэсийн агуулга ядуу (Cu 0.007-0.05, ховорoor 0,97-1%) учир хэтийн төлөв муутай.</p> <p>Номт талбайд илрүүлсэн зэсийн 0.05% захын агуулгаар хүрээлэгдсэн хүдэр, металлын баялгийг Р1 зэргээр 21408.27 тн тогтоогдон, параметруүд нь бага учир дунд, жижиг хэмжээний орд үүсгэх ба илрэлүүд нь хэтийн төлөвийн ач холбогдол багатай хэмээн үнэлгээ өгсөн.</p> <p><b>3. Эрэл-үнэлгээ - 3 - 2021.</b> Геосигналс ХХК-ийн гүйцэтгэсэн Дорнод аймгийн Дашбалбар,</p>	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									<p>Чулуунхороот, Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумдын нутагт 2021-2023 онд гүйцэтгэсэн эрэл үнэлгээ-3 төслийн үр дүнгийн тайлан эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар хамгаалагдсан.</p> <p>Давхаргазүйн 8 формац, гүний 4 бүрдэл тархсан металогений 1 бүс, хүдрийн 1 дүүрэг, 1 зангилаа, Авдартолгой талбайд хамаарна. Алт- зэс, алт-полиметаллын хүдэржилт бүхий хэтийн төлөвтэй талбайнуудыг ялгасан.</p> <p>Эрлийн талбай-1-ийн хэмжээнд: Бага уулын зэсийн хүдрийн 20 биетэд С зэргээр 6711 тн зэсийн нөөц, уг хүдрийн биетийг хүрээлж Р1 зэргээр 15359 тн зэсийн баялгийн үнэлгээ өгсөн. Талбайн литогеохимиийн дээжлэлтийн үр дүнгээр Р1-305240 тн, Р2-2619281 тн, Р3-2911747 тн зэсийн баялгийн үнэлгээ өгсөн.</p> <p>Соёо-Өндөрийн участокийн хэмжээнд хүдрийн гүний хэсэгт Р1- 88,763.67 тн зэсийн баялаг үнэлэгдсэн ба цаашид талбайн хэмжээнд нөөцийн хэмжээ өсөх магадлалтай. Талбайн литогеохимиийн дээжлэлтийн үр дүнгээр Р1-67307тн, Р2-151054 тн, Р3-223958 тн зэсийн баялаг тооцсон.</p> <p>Ил түрүүтийн алт- мөнгөний хүдэржилтийн талбайд үнэлгээ өгөхдөө Р1 зэргээр мөнгийг алт руу эквивалентад шилжүүлж тооцсон. Р1 баялгийг 576,62 к/г алт үнэлэгдсэн. Талбайн литогеохимиийн дээжлэлтийн үр дүнгээр Р2-5,8 тн алт, Р2-1949 тн зэс, Р3- 12045 тн зэсийн баялгийн үнэлгээ өгсөн.</p> <p>Судлын төрлийн хүдэржилт бүхий Баянцагааны талбайд Р1 зэргээр 7,766,73 тн металл зэсийн баялгийг тооцсон. Багахан хэсэгт нэвтэрсэн цооногт 5527.8 тн цэвэр вольфрам байна. Литогеохимиийн дээжлэлтийн үр дүнд гянтболдын баялгийн үнэлгээгээр Р1- 6715 тн, Р2- 14861 тн, Р3 -17765 тн-оор тооцсон.</p>	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									<p>Лутаагийн давхацмал хүдэржилттэй холимог металлын хүдэржилт бүхий талбайн литогеохимиийн дээжлэлтийн үр дүнгээр баялгийн үнэлгээг Р3 зэргээр 76409 тн зэс, Р3-10287 тн гяантболд тооцсон.</p> <p>Эрлийн талбай-2-ийн хүрээнд: Хлоритийн алтны скарны хүдрийн биетийг хүрээлэх алтны 0.1 г/т захын агуулгаар С зэргээр 77.12 кг алтны нөөц, Р1 зэргээр 27.6 кг алтны баялаг тооцсон. Нуурын алтны судлын 2 биетэд 0.63г/т алтны агуулгатай баялгийг Р1 зэргээр 494.32 кг-аар тооцсон.</p> <p><b>4. Эрэл – үнэлгээ – 4 - 2022.</b> Говь-Алтай аймгийн Баян-Уул, Шарга сумдын нутагт “Геологийн судалгаа шинжилгээний төв” ТӨҮГ-ын гүйцэтгэж буй төслийн ажлын эцсийн суурин боловсруулалтыг 2024 оны 12 дугаар сарын 31-нд дуусна.</p> <p>Задгай ам Au; Хавхааст худаг Au-Cu; Хавтгайн цахирын нүүрс, Ширдэгт- Төв илрэлүүдийг ялгаж, нарийвчилсан эрлийн ажил хийсэн.</p> <p>Задгай ам илрэлийн кварц-пирит-малахитат судал, судланцарын бүсэд Au-0.01г/т-16.4г/т, Ag-1-7г/т, Cu-0.04%. Анхдагч геохимиийн 366ш сорьцод Au 0.1г/т агуулгатай хоёр сарнилын хүрээ тогтоогдсон. Хавхааст худаг-Au илрэл, кварц-пирит-халькопиритэт судлын 7 дээжид Au-0.26-6.5 г/т, 3 дээжинд Cu-0.6%. Анхдагч геохимиийн 347ш сорьцод Au-ны 0.1г/т агуулгатай хоёр сарнилын хүрээ илэрсэн. Дээд юрийн Жаргалант формацийн тунамал хурдаст 0.2-2.5м хүртэл зузаантай хүрэн нүүрсний нимгэн 17 ўе илэрсэн. Хавтгайн цахир илрэлийн (130м) нүүрс нь 3325-4960 ккал/кг илчлэгтэй. Нүүрсний таамаг баялгийг 35.6мян.тонн-оор тооцсон. Ширдэгт (Төв) (Au-Cu(Zn, Pb) ийн илрэл дээр 2 цооног (ShDDH-5, 9) нэмж өрөмдсөн. 2.12 г/т -18м (58-76м интервалд), максимум -35.05 г/т (ShDDH-05); 0.53 г/т-32м (77-109м интервалд), максимум -9.32 г/т (ShDDH-05);</p>	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									0.43 г/т-23м (27-50м интервалд, ShDDH-09) үеүд илрэх төлөвтэй. <b>5.Мета алт - 500.</b> Магнетик сурвей ХХК-ийн гүйцэтгэж буй төслийн талбайн хэмжээнд ялгасан Тээг толгой, Занги, Замын ам, Сэнжитийн хяр, Зангат, Олон -Овоот, Дэл хайрхан, Шар Ухаа, Овоот, Бор цахир, Эрдэнэ Монгол баруун, Хөөврийн цахир, Цагаан хад, Завсрын толгод, Зараат, Ямаат, Завтын хяр уул, Будагт, Улаан хийд талбайг ангилах, 2022-2024 онд цуглуулсан дээж, ялгасан үнэлэх, нэгдсэн таних тэмдэг, төслийн суурь зураг зураг зэрэг суурийн боловсруулалтын ажлууд хийж байна. Ялгасан талбайнуудын далд тогтцыг судлах, цаашдын судалгааны ажлын чиглэлийг гаргах, үнэлгээ өгөх зорилгоор, соронзон зураглал 650 т.км, гамма-спектрометрийн зураглал 200 т.км, TEM 468 ф.ц, АТ-ДГ 125 т.км, АТ-ПД 60 т.км ажлуудын боловсруулалт, тайлалтын ажил гүйцэтгэж байна. 2700 дээжид Алтны шинжилгээ FAE303, FAA303, ICP14B, ICM40B, ICM90A шинжилгээ, 2500 дээжид хувирлын минералогийн хэмжилт, Стандарт дээж худалдаж авах зэрэг ажил гүйцэтгээд байна. Нийт дээжээс 200 ширхгийг сонгож лабораторийн гадаад хяналт хийлгэхээр өгсөн.	
Дундаж үнэлгээ:										96.66%

## ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

2024 оны 12 дугаар сарын 09